



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/306

Чингис хот

Ц.Дамдины цэцэрлэгт хүрээлэнгийн
тохижилтын ажилд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ийн "г", Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын ардын багш, гавьяат тамирчин, олимпийн мөнгөн медалт, дэлхийн хошоо аварга Ц.Дамдины дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Баян-Адарга суманд байгуулагдаж байгаа цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажилд зориулан 1.000.000 /нэг сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

201010437